



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 30

Эрдэнэт

Ойгоос бэлтгэх модны хэмжээ
батлах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1,2 дахь заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17,1,4 дэх заалт, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын Сайдын 2015 оны А/415 дугаар тушаалыг тус тус үндэслэн Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Ойн менежментийн төлөвлөгөө, ойн нөөцийг харгалзан 2016 онд Жаргалант сумын ойн сангаас ойн цэвэрлэгээгээр бэлтгэх хэрэглээний шинэс модны дээд хэмжээг 100 шоометр, түлээний шинэс модны дээд хэмжээг 4000 шоометрээр тус тус тогтоож баталсугай .

2. Холбогдох хууль, журмын дагуу бэлтгэх модны хэмжээг энэ хязгаарт багтаан тогтоож, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлэхийг Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвшөөрсүгэй.

3. Баян-Өндөр сум /Эрдэнэт хот/-ын иргэдийн түлшний модны хэрэгцээг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын Сайдын 2015 оны А/415 дугаар тушаалын 4 дэх заалтын дагуу Ойн цэвэрлэгээ хөтөлбөр хэрэгжиж байгаа аймагтай харилцан тохиролцож, түлээний модоор хангах асуудлыг шийдвэрлэхийг аймгийн Засаг дарга /С.Дангаасүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Б.МЯГМАРСҮРЭН

C:\Togtool \-A4 doc

00100043